



ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



JAPAN INTERNATIONAL
COOPERATION AGENCY

**Улаанбаатар хот дахь ХБИ-ийн нийгмийн оролцоог дэмжих төсөл
(DPUB)**

Мэдээллийн эмхэтгэл №13 (2018 он 5-р сар)

**ЧИНГИС ХААН ОУНБ ДАХЬ СУРГАЛТ :
БҮХ ХҮМҮҮСТ ЭЭЛТЭЙ НИСЭХ БУУДАЛ**

Сургалт эхэллээ (2018.05.08)

5 сарын 7-ны өдөр Чингис хаан олон улсын нисэх буудлын ажилчдад зориулсан сургалт эхэллээ. Нисэх буудлын сургалт 5-р сард 7 хоног, 8 болон 11-р саруудад тус бүр 7 хоног зохион байгуулагдах төлөвлөгөөтэй байна. Сургалтанд өдөр бүр 30 хүн хамрагдах ба 11-р сар гэхэд нийт 450 ажилтан оролцсон байх юм. Хөтөлбөрийн тухайд үдээс өмнө нь хөгжлийн бэрхшээлийн талаар хамтдаа ярилцах “Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET)”, үдээс хойш нь ХБИ-дэд хэрхэн үйлчилгээ, тусламж үзүүлэх вэ гэсэн сэдвээр дадлага сургалт явагдана. Сургалтын эхний өдөр тог тасарч, проектор ашиглах боломжгүй болсон ч DET Forum-н хамт олон нөхцөл байдалдаа тохируулан сургалтаа амжилттай явууллаа. Сургагч багш нар “өглөөнөөс орой хүртэл, 5 өдөр дараалан сургалт явуулах нь ачаалалтай хэдий ч Монгол улсын нүүр царай болох нисэх буудлын хамт олонд сургалт явуулах нь сайхан байна” хэмээн өгүүлж байлаа. Дэлхийн өнцөг булан бүрээс ирэх хүмүүст сайхан сэтгэгдэл үлдээхийн тулд хамтдаа хичээцгээе!



DET сургалтын үеэр



JICA DPUB
фэйсбүүк
хуудсанд

LIKE дарж нэгдээрэй!!

Төслийн фэйсбүүк хуудсанд LIKE дарсан нийт хүний тоо **2284** болж, маш олон хүнд төслийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл хүрэх боллоо. Цаашид ч гэсэн олон сонирхолтой мэдээлүүдийг та бүхэнд хүргэхийн тулд хичээн ажиллах болно.

Сонголын бэрхшээлтэй иргэдэд хэрхэн үйлчлэх тухай (2018.05.08)



Оролцогчид дадлага ажил хийж байна

Сонголын бэрхшээлтэй иргэдэд хэрхэн үйлчилгээ, тусламж үзүүлэх тухай сургалтыг сургагч багш Нэмэхбаяр хариуцан явууллаа. Түүний хувьд практик сургалтыг анх удаа хариуцаж явуулсан болохоор бага зэрэг сандарч байсан ч сургалтын явцад энэ байдал нь арилж, сургалтаа амжилттай явуулсан. Эхлээд нисэх буудал дээр сонголын бэрхшээлтэй хүнд тулгамддаг асуудлуудын талаар тайлбарласны дараа хэрхэн харилцах, туслах аргын талаар дадлага сургалт явууллаа. Сонголын бэрхшээлтэй хүнтэй бичгээр харилцахдаа гол санаагаа ойлгомжтой тодорхой бичих, газрын зураг, зурагт хуудас зэргийг урьдчилан бэлтгэн тавьснаар ямар ч хүнд ойлгомжтой тайлбар өгөх боломжтой гэх мэт зүйлүүдийг ярьж байлаа. Мөн сүүлийн үед сонголын бэрхшээлтэй хүмүүс ухаалаг утас ашиглан асуулт тавих, хүмүүстэй харилцах хандлага их байгаа гэж байсан. Сургалтанд оролцож байгаа ажилтнууд эхэндээ хэрхэн харилцах учраа сайн олохгүй байсан ч Нэмэхбаяр багшийн тайлбарыг сонсон үзэг цаас, гар утас ашиглан харилцах дадлага хийлээ. Дадлагын үеэр чихэвч зүүгээд ярьж чаддаг ч сонсож чаддаггүй хүний дүрд тоглосон нь үр дүнтэй болсон юм.

**ТББ дахь ажил “Камбож дахь
далангийн судалгааны ажлын тухай”**



DPUB төслийн ахлах зөвлөх
Чиба Хисао

Даланг дахин сэргээн барих судалгааны ажлыг Камбож хүнтэй хамт хоёулаа хариуцан хийхээр боллоо. Бид хоёр хоёулаа далангийн судалгааны ажлыг анх удаа хариуцаж хийх

болсон ба ялангуяа миний хувьд Камбож улсад ч тэр, ТББ-д ч тэр анх удаагаа ажиллаж үзсэн юм. Мэдээж эхэн үедээ ажлын арга барилаа сайн олохгүй байсан хэдий ч хамтрагч маань маш найрсаг, англи хэлтэй, судалгааны материалтай уншиж танилцан бусдын санал хүсэлтийг ч гэсэн сайн сонсдог байсан учраас хамтарч ажиллахад надад маш их тус дэм болсон. Одоо ингээд бодоход би дандаа сайхан хүмүүстэй хамт ажиллаж иржээ. Өөр улс оронд очоод өөр ахуй, соёлтой хүмүүстэй хамтарч ажиллахад үл ойлголцох зүйл гардаг байж магадгүй ч миний хувьд өнөөг хүртэл сэтгэл дундуур байсан үе байхгүй. Жижиг сажиг юм бүхэнд ач холбогдол өгөлгүй, хэн хэндээ хүндэтгэлтэй харьцаад явбал ажил үйлс аяндаа л бүтдэг гэж би боддог. Ажлын тухайд гэвэл байгаль орчныг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ТББ, хот хөгжүүлэлтийг дэмжин ажиллаж буй Засгийн газар хоёрын дунд ямар тайлан боловсруулж гаргавал зохистой эсэх тал дээр нэлээд хэцүү байдалд орсон. Би өөрөө ТББ-д ажиллаж байсан учраас байгал орчныг хэвээр нь үлдээх байр суурьтай байсан хэдий ч далан барина гэдэг нь байгаль орчныг эвдлэн сүйтгэнэ гэсэн ойлголттой бүрэн дүүрэн санал нийлэхгүй байлаа. Мэдээж судалгааныхаа явцад барилгын компани, ЖАЙКА-тай уулзаж ярилцсан ба бүгд л Камбож улс дахь бүтээн байгуулалт, байгаль орчны хамгаалалт хоёрт аль алинд нь ач холбогдол өгөн ажиллаж байсан. Харин ТББ-ынхан хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь хангалтгүй, бүс нутгийн ард иргэд эсэргүүцэхийн сацуу үерийн бүсийн ард иргэдэд өгөх нөхөн олговор хангалтгүй гэж үзэж байлаа. Иймд, Камбожийн Засгийн газар дахин сэргээх ажлаа больж, үр дүнд нь далан баригдаагүй. ТББ-ын хувьд баяртай мэдээ байсан хэдий ч миний хувьд бидний ажлын үр дүн гэж хэлэхэд хэцүү, нэг л хангалтгүй санагдаж байсан. Гэхдээ хагас жилийн судалгааныхаа үр дүнг нэгтгэж Камбожийн Засгийн газар болон Олон улсын дэмжигч байгууллагуудад хүргүүлсэн юм. Энэ нь Олон улсын хамтын ажиллагааны салбар дахь миний бичсэн анхны тайлан байсан бөгөөд одоо бодоход маш сайхан дурсамжтай санагдаж байна. (Үргэлжлэл бий...)

Харааны бэрхшээлтэй иргэдэд хэрхэн үйлчлэх тухай (2018.05.10)

Үдээс өмнөх DET сургалтын дараа оролцогчид 3 багт хуваагдан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хэрхэн



Сургалтын үеэр

үйлчилгээ үзүүлэх талаар суралцаж байна. Харааны бэрхшээлтэй хүмүүст үйлчилгээ үзүүлэх сургалтын үеэр ажлчид нүдний хаалт болон таяг ашиглаж, өөрийн бие дээр туршиж үзэнгээ үйлчилгээний аргад суралцаж байна. Монголын хараагүйчүүдийн үндэсний холбооны Туул багш "Хамгийн чухал нь эхлээд үйлчлүүлэгчээс асууж зөвшөөрөл авсны дараа туслах хэрэгтэй" гэж ярьж байлаа. Оролцогчид 2, 2-оороо 1 баг болоод угаалгын өрөө орох, шатаар явах, сандалд суулгаж өгөх зэрэг дадлагуудыг хийсэн. "Гэнэт биед нь хүрэх, гарнаас нь татах нь зохисгүй" байдаг гэх мэтээр муу жишээг ч туршиж үзсэн нь үр дүнтэй байлаа. Онгоцны буудалын албан хаагчид зөв, зохистой үйлчилгээний аргад суралцан цаашид үйлчилгээгээ улам сайжруулна гэдэгт итгэлтэй байна.

Тэргэнцэртэй иргэдэд үйлчилгээ үзүүлэх тухай (2018.05.15)

“Тэргэнцэр”-ийг зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй иргэд хэрэглэдэггүй. Өндөр настан, гэмтэж бэртсэн хүмүүс, бие муутай хүмүүс ч гэсэн хэрэглэх боломжтой. Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудлын албан хаагчид хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хэрхэн



Шатаар өгсөх, уруудах дадлага

үйлчилгээ үзүүлэх олон аргачлалын талаар суралцлаа. Тэдгээрийн нэг нь тэргэнцэртэй иргэдэд туслах, үйлчилгээ үзүүлэх аргачлал байсан юм. Тус сургалтыг Түгээмэл Хөгжил бие даан амьдрах төвийн Лхамжав, Ням-Очир зэрэг мэргэшсэн ажилчид хариуцан явуулсан. Тэргэнцэр хэрэглэж буй хүмүүсийн нөхцөл байдал, хэрэгцээ шаардлага нь өөр хоорондоо адилгүй. Өөрөө тэргэнцэртэйгээ явж чадах хүн байхад хэн нэгнээр түрүүлэх шаардлагатай хүн, тэргэнцэртэйгээ явж чадах боловч тэргэнцэрээсээ сандал руу шилжиж суухад хүндрэлтэй хүн... гэх мэт олон янз байдаг. Тийм учраас “Юуны өмнө хэрэглэгчийн хүсэлтийг асуух шаардлагатай. Тэргэнцэр нь тухайн хүний биеийнх нь нэг хэсэг гэсэн үг. Зөвшөөрөлгүйгээр битгий түрээрэй.”, “Туслацгаа үзүүлэх хүн ч гэсэн өөрийн аюулгүй байдлыг ханган ажиллах хэрэгтэй. Биеийн хүчийг хуваарилаж, зөв дарааллаар өргөх хэрэгтэй” хэмээн багш нар сургалтанд оролцогчдод зөвлөгөө өгсөн юм. Мөн догол газарт тэргэнцэртэй хүнийг өргөх, буулгах, цахилгаан шатанд хэрхэн суух аргачлалын талаар суралцсан. Түүнчлэн ээлж ээлжээрээ тэргэнцэр дээр сууж, тэргэнцэртэй зорчиход ямар байдаг талаар өөрийн биеэр туршиж үзлээ.

Баярлалаа (2018.05.15)

“Улаанбаатар хот дахь ХБИ-ийн нийгмийн оролцоог дэмжих төсөл (DPUB)” 5-р сарын 7-оос 11-ний 5 өдрийн хугацаанд “Чингис хаан” Олон Улсын Нисэх Буудлын албан хаагчдад зориулж Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET), Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хэрхэн үйлчилгээ үзүүлэх тухай сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд өдөр бүр 20 орчим албан хаагчид хамрагдсан бөгөөд нийтдээ 100 гаруй албан хаагчид оролцлоо. Нисэх онгоцны



Сургалтыг Чингис Хаан ОУНБ-ын зүгээс өндрөөр үнэллээ

буудлын удирдах албан хаагчид тус сургалтыг өндрөөр үнэлсэн бөгөөд DPUB төслийн хамт олонд талархал илэрхийлж “Чингис хаан” бэлэг дурсгалын зүйлийг гардуулж өглөө. Төслийн зүгээс цаашид ХБИ-ийн нийгмийн оролцоог дэмжих чиглэлээр улам илүү хүчин чармайлт гарган ажиллах болно.

DPUB Холбоо барих хаяг

Хаяг: Монгол улс,
Улаанбаатар-15160, Нэгдсэн
үндэстний гудамж-5, Засгийн
газрын 2-р байр, ХНХЯ

Фэйсбүүк хуудас: [https://
www.facebook.com/jicadpub](https://www.facebook.com/jicadpub)

Цахим хуудас: [https://
www.jica.go.jp/project/
mongolia/015/index.html](https://www.jica.go.jp/project/mongolia/015/index.html)

И-мэйл: dpub.jica@gmail.com

